



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаах авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Нийтийн тээврийн автопарк”, “Нийтийн тээврийн автобус” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600, дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй 50, их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 35 автобус, цахилгаан автобусны цэнэглэх төхөөрөмж 6 ширхэг нийт 201,456,106,066.50 (хоёр зуун нэг тэрбум дөрвөн зуун тавин зургаан сая нэг зуун зургаан мянга жаран зургаан төгрөг тавин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг нийслэлийн өмчид, их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 20 автобус, цахилгаан автобусны цэнэглэх төхөөрөмж 4 ширхэг, нийт 12,817,245,600.00 (арван хоёр тэрбум найман зуун арван долоон сая хоёр зуун дөчин таван мянга зургаан зуу) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Дархан-Уул аймгийн өмчид тус тус хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Бат-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэл, аймагт бий болсон үндсэн хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 376 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бодгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны... дугаар сарын... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1.Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүртгэх нийт үнэ
				(төгрөг)	
1	Их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй автобус	2023	35	625,493,880.00	21,892,285,800.00
2	Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус	2023	600	275,983,200.00	165,589,920,000.00
3	Дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус	2023	50	270,256,965.33	13,512,848,266.50
4	Цахилгаан автобусны цэнэглэх төхөөрөмж	2023	6	76,842,000.00	461,052,000.00
Нийслэлийн өмчид бүртгэх нийт дүн					201,456,106,066.50

2.Дархан-Уул аймгийн өмчид бүртгэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүртгэх нийт үнэ
				(төгрөг)	
1	Их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй автобус	2023	20	625,493,880.00	12,509,877,600.00
2	Цахилгаан автобусны цэнэглэх төхөөрөмж	2023	4	76,842,000.00	307,368,000.00
Дархан-Уул аймгийн өмчид бүртгэх нийт дүн					12,817,245,600.00
					214,273,351,666.50
Нийт дүн			(хоёр зуун арван дөрвөн тэрбум хоёр зуун далан гурван сая гурван зуун тавин нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг тавин мөнгө)		